

## Материалын таних тэмдэглэгээ – бол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны системийн хамгийн эхний дамжлага

2021 оны 1-р сар



### Химийн бодис хадгалах савнууд ихэвчлэн хоорондоо

#### адилхан байдаг.

Ажилтан олон ширхэг боошигноос түүхий материал юүлэх ажил гүйцэтгэж байсан. Бүх боошиг хар өнгөтэй, цагаан амсартай бөгөөд шошго нь цэнхэр болон цагаан өнгөтэй байсан. 20 ширхэг орчим боошиг юүлсний дараа ажилтан нэг боошигны шошгон дээрх нэр өөр байгааг анзаарсан. Тус боошиг бусад боошигтой адил хар-цагаан өнгөтэй, шошго нь мөн ижил цэнхэр-цагаан өнгөтэй боловч доторх материалын хувьд өөр байсан. Ажилтан инженерээ дуудсан ба тэрбээр түүнд боошигийг юүлэхгүй орхих, зохих арга хэмжээг тодорхойлох хүртэл тусгаарлах зааварчилгаа өгсөн.

Хэрэв ажилтан тухайн материалыг анзааралгүй юүлчихсэн бол юү тохиолдох байсан бэ? Үүнийг мэдэх боломжгүй боловч наад зах нь материалын чанартай холбоотой асуудал үүсч, компанид их хэмжээний санхүүгийн хохирол учирч, мөн магадгүй захиалга алдагдах байсан.

Аюулгүйн хяналт яагаад ажиллаагүй вэ? Ханган нийлүүлэгч боошигнуудыг подон дээр ачихдаа алдаа гаргасан. Түүнчлэн компанийн агуулахад материал хүлээн авсан ажилтан тухайн хүргэлтийн үед олон тооны боошигны дунд огт өөр төрлийн материал бүхий боошиг байгааг олж хараагүй. Энэ бүх систем нь ажилтнуудын дүрэм журмыг мөрдөх, ажлын процесст бүрэн анхаарал хандуулах байдлаас хамааралтай байдаг.

Дээрх жишээний нэгэн адил химийн бодистой холбоотой олон үйл ажиллагаа тухайн ажлыг алдаагүй гүйцэтгэж буй ажилтнуудаас онцгой хамааралтай. Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны олон системийн хувьд хүлээн авсан материалын хаягжилтын найдвартай байдалд тулгуурладаг. Ханган нийлүүлэгч химийн бодисын хаягжилтыг ЗӨВ хийсэн тохиолдолд ирсэн материалыг сканнераар шалгаж, химийн бодисын мэдээллийг илүү нарийн тогтоох боломжтой.

### Та мэдэх үү?

- Савлагаатай эсвэл их хэмжээний химийн бодис хүлээн авах системүүд нь захиргааны хяналтад тулгуурладаг. Ажилчид дүрэм журмыг мөрдөж, деталь бүрийг цаг ямагт анхааралтай ажиглах ёстой. Анхаарал бага зэрэг сулрахад л ноцтой асуудал учирч болзошгүй.
- Тухайн ажилд анхаарал төвлөрсөн үед ч хүн алдаа гаргах боломжтой. Онгоцны эсвэл сансрын нисгэгч гэх мэт өндөр түвшинд бэлтгэгдсэн ажилтнуудын хувьд ч алдаа гаргахгүй байх магадлал 99% байдаг.
- Зарим компани “дөрвөн нүд”-ний зарчмыг ашигладаг. Өөрөөр хэлбэл нэг хүн тухайн бэлтгэл эсвэл үйл ажиллагааг хөндлөнгөөс ажиглаж, журам мөрдөгдөж буй эсэх болон бусад бүх процессыг хянадаг. Их хэмжээний материалыг буруу танк руу шахах ноцтой үр дагавар учруулсан тохиолдол олон байдаг. Заримдаа хальж асгарах зэрэг сөрөг нөлөөг дагуулдаг. Мөн бусад алдаа доголдлын улмаас химийн урвал явагдах, амь эвсэнд аюултай бодис алдагдах, танк бохирдох, санхүүгийн хохирол гэх мэт асуудал үүсдэг.
- Боошиг, хуванцар сав, цистенр танк зэрэг савыг олон ширхгээр өрөх үед өөр хоорондоо ижилхэн харагддаг. Тиймээс зөв хаягжилт гэдэг бол нэн чухал зүйл юм.
- Шингэн бодис хадгалдаг хуванцар сав болон хатуу материалд зориулагдсан гялгар уут зэрэг дунд оврын савыг зөөхөд буруу тоног төхөөрөмж (буруу шланг) эсвэл буруу сэрээт техник ашигласны улмаас их хэмжээний бодисыг олон удаа ачих, буулгах тохиолдол гардаг.

### Та юу хийж болох вэ?

- Хэрэглэгч болон ханган нийлүүлэгч их хэмжээний эсвэл савлагаатай материалтай харьцахдаа дүрэм журмыг тогтмол мөрдөх ёстой. Журамд алдаа дутагдал байгаа бол ялган тэмдэглэж, ахлах ажилтанд мэдэгдэж засуулах хэрэгтэй.
- Савлагаатай эсвэл их хэмжээний химийн бодис зөөвөрлөхөд заавал зөвшөөрөгдсөн буюу зориулалтын тоног төхөөрөмжийг ашигла.
- Ханган нийлүүлэгчээс ирсэн сав болон дотоодын хэрэглээнд ашигладаг савны хаягжилтын аль алинд нухацтай анхаарал хандуул. Лабораторын дээжний шил гэх мэт маш жижиг хэмжээтэй савыг ч зөв хаягжуулах шаардлагатай.
- Их хэмжээний бодисыг тээвэрлэхэд тусгай төрлийн хаягжилт ашигладаг ба материалыг буулгахаас ӨМНӨ хүлээн авагч тал доторх агуулгыг шалгаж баталгаажуулах хэрэгтэй. Зарим компани агуулгыг баталгаажуулахын тулд материалын дээжийг лабораторт шинжилж, тээвэрлэлтийн бичиг баримттай тулгадаг. Их хэмжээний материал тээвэрлэх үед бүх бичиг баримт бүрэн бөгөөд зөв эсэхийг нягтлан шалга.

**Химийн бодис хүлээн авах процесст алдаа гаргахгүй байх нь дараачийн бүх шат дамжлагыг эрсдлээс хамгаалах нэн чухал алхам юм.**